



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА СЭЛЭНГЭ АЙМГИЙН АУДИТЫН ГАЗАР

СЭЛЭНГЭ-ЭНЕРГО ОРОН НУТГИЙН ӨМЧИТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН

Эрх бүхий байгууллага, албан тушаалтны зүгээс үйл ажиллагааг нь үнэлж дүгнэдэггүй, үр нөлөө бүхий дотоод хяналт хийгддэггүй бөгөөд орлогоороо зардлаа нөхөж чадахгүйгээс алдагдал, авлага, өр төлбөр жил ирэх бүр нэмэгдэж, хэвийн үйл ажиллагаа явуулах нөхцөл боломж алдагдаж байна.



Сүхбаатар сум

2016 он

<u>Тайланг бэлтгэсэн:</u> ҮАГ-ын харьяа Сэлэнгэ аймгийн Аудитын газар Тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа Аудитын менежер Б.Батмөнх Шинжээч А.Дашбат 2016 оны 09 сар Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 70362442 дугаарын утас, 70363040 дугаарын факсаар харилцана уу. ХАЯГ: Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сум, аймгийн ЗДТГ-ын байрны өргөтгөлд	ТАЙЛАНГИЙН АГУУЛГА Нэг. Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй Хоёр. Үндсэн мэдээлэл Гурав. Аудитын дүн БҮЛЭГ 1. Сэлэнгэ-Энерго ОНӨААТҮГ-ын үйл ажиллагаа нь холбогдох хууль, эрхийн актын хүрээнд, үр нөлөөтэй хэрэгжиж байна уу? 1.1 Үйл ажиллагаа нь холбогдох хууль эрхийн актын хүрээнд үр нөлөөтэй хэрэгжиж байна уу? 1.2 Үйл ажиллагааны төлөвлөгөө, үр дүнгийн тайланг ТУЗ болон холбогдох бусад байгууллагаар хэлэлцэж үнэлэлт, дүгнэлт өгөгдөж байна уу? 1.3 Үндсэн болон санхүүгийн үйл ажиллагаанд дотоод хяналт хийгдэж байна уу. БҮЛЭГ 2. ОНӨААТҮГ-нь орлого, зарлагаа үндэслэлтэй төлөвлөж, үр ашигтай ажиллаж байна уу? 2.1 Үйл ажиллагааны орлогыг бүрэн дүүрэн, үндэслэлтэй төлөвлөн төвлөрүүлж байна уу? 2.2 Төвлөрсөн орлогыг үр ашигтай, арвилан хэмнэлттэй зарцуулж байна уу? 2.3 Авлага, өглөгийг барагдуулж, үр ашигтай ажиллаж байгаа эсэх. БҮЛЭГ 3. Хөрөнгийн худалдан авалт, ашиглалт, зарцуулалт арвилан хэмнэлт, үр ашигтай байна уу? 3.1 Худалдан авах ажиллагааг холбогдох хууль, эрхийн актын хүрээнд зохион байгуулж байна уу? 3.2 Хөрөнгө нөөцийг хэрэгцээ, шаардлагын хэмжээнд бэлтгэн, ашиглаж байна уу? 3.3 Хөрөнгийг бүртгэл тооцоонд бүрэн тусгаж, тооллого, тооцоог цаг хугацаанд нь гүйцэтгэж байна уу? Дөрөв. Аудитаар илрүүлсэн зөрчил Тав. Дүгнэлт Зургаа. Аудитын зөвлөмж Холбогдох байгууллагын санал: Саналд өгсөн тайлбар
---	--

Товчилсон үгийн тайлбар

МУ	Монгол Улс
ЗХУ	Зөвлөлт Холбоот Улс
УИХ	Улсын Их Хурал
ЗГ	Засгийн газар
ҮАГ	Үндэсний аудитын газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
ИТХТ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тэргүүлэгчид
МХГ	Мэргэжлийн хяналтын газар
ТБОНӨТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
ТБОНӨХБАҮХА	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах
НББ	Нягтлан бодох бүртгэл
НББОУС	Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ААНБ	Аж ахуйн нэгж байгууллага
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ТУЗ	Төлөөлөн удирдах зөвлөл
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ДШС	Дулааны шугам сүлжээ
ББӨ	Борлуулсан бүтээгдэхүүний өртөг

Нэг. Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй

1.1. Аудит хийсэн үндэслэл

Аудитыг Сэлэнгэ аймгийн Аудитын газрын 2016 оны бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний төлөвлөгөөг үндэслэн Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд хийв.

1.2 Аудитын зорилт, хамарсан хүрээ

Сэлэнгэ аймгийн Сэлэнгэ-Энерго орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын үйл ажиллагааны үр дүнд аудит хийж, дүнг холбогдох байгууллага, албан тушаалтнуудад танилцуулахад аудитын зорилт чиглэгдэнэ. Аудитын зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудит хийж гүйцэтгэлээ. Үүнд:

- ❖ Сэлэнгэ-Энерго ОНӨААТҮГ-ын үйл ажиллагаа нь холбогдох хууль, эрхийн актын хүрээнд, үр нөлөөтэй хэрэгжиж байна уу?
- ❖ ОНӨААТҮГ-нь нь орлого, зарлагаа үндэслэлтэй төлөвлөж, үр ашигтай ажиллаж байна уу?
- ❖ Хөрөнгийн худалдан авалт, ашиглалт, зарцуулалт арвилан хэмнэлт, үр ашигтай байна уу?

Аудитаар “Сэлэнгэ энерго” ОНӨААТҮГ-ын 2015, 2016 оны 1-5 сар хүртэлх үйл ажиллагааг хамруулав.

1.3 Аудитын арга зүй:

Аудитын явцад Төрийн хяналт шалгалтын стандартыг мөрдөж, Гүйцэтгэлийн аудитын арга зүйг (АДБОУС 3000-3100) ашиглан Сэлэнгэ-Энерго ОНӨААТҮГ-ын захирал, нягтлан бодогчид, нярав болон инженер, техникийн ажилтнуудтай ярилцлага хийх, асуулга лавлагаа, тодруулга авах, байгууллагын үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан, бусад шаардлагатай баримт материалд тулгуурлан дүн шинжилгээ хийн, аудитын хөтөлбөр, горим, асуудлын шинжилгээний дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсруулав.

1.4 Аудитын шалгуур үзүүлэлт, хугацаа

Аудитад хууль, эрх зүйн актуудыг шалгуур үзүүлэлт болгон ашиглав. Үүнд:

- Төрийн аудитын тухай хууль
- Төсвийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Хөдөлмөрийн тухай хууль
- Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- ТБОНӨХБАҮХАТ хууль
- ААНОАТ-ын тухай хууль
- НӨАТ-ын тухай хууль
- Компаний тухай хууль
- Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль
- Шилэн дансны тухай хууль

- Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, дээрх хуулиудыг хэрэгжүүлэхтэй холбогдуулан гаргасан УИХ, Засгийн газрын тогтоол, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын тогтоол, Засаг даргын захирамж зэрэг бусад эрх зүйн актууд зэрэг болно.

Аудитыг Сэлэнгэ аймгийн Аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа удирдаж, аудитын менежер Б.Батмөнх явцын болон чанарын хяналтыг гүйцэтгэн, шинжээч А.Дашбат 2016 оны 05 дугаар сарын 23-ны өдрөөс 09 дүгээр сарын 05-ны өдрийн хооронд хийж гүйцэтгэв.

Хоёр. Үндсэн мэдээлэл

“Сэлэнгэ энерго” ОНӨААТҮГ-нь 1990 онд ЗХУ-ын техник эдийн засгийн тусламжтайгаар 125 тн.цаг-ийн хүчин чадалтай, КЕ-25/14 маркийн 5 уурын зуухтайгаар Сэлэнгийн эрчим хүчний нэгдсэн үйлдвэрийн харьяа Сүхбаатар хотын дулааны станц нэртэйгээр ашиглалтанд орсон.

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2000 оны 07 дугаар сарын 21-ний өдрийн 60 дугаар тогтоолоор “Сэлэнгэ энерго” ОНӨААТҮГ болон зохион байгуулагдаж, дулааны эрчим хүч үйлдвэрлэх, түгээх, зохицуулалттай хангах тусгай зөвшөөрөлтэйгээр үйл ажиллагаа явуулж байна .

Өнөөгийн байдлаар КЕ-25/14 маркийн 3, КВТС-20/150 маркийн 1, DZL-2.8 1 зуухтай, 40 км төв ба салбар шугамтай, 7 дулаан хуваарилах төвтэйгөөр дулааны станц, дулааны шугам сүлжээ, захиргаа аж ахуй гэсэн 3 үндсэн хэсэгт 116-120 ажилтан ажиллаж, жилд дунджаар 37.0 мян.тн нүүрс, 2.8 сая квт/ц цахилгаан эрчим хүч, 158 мянган м3 ус хэрэглэж байна.

Тус үйлдвэрийн газрын захирлаар Ш.Оргил 2009 оноос 2016 оны 04–р сарын 01 хүртэл, ерөнхий нягтлан бодогчоор Д.Ванчигмаа 2011 оноос хойш ажиллаж хөрөнгө, мөнгө зарцуулах 1,2-р гарын үсгийн зурж иржээ.

Гурав. Аудитын дүн

Бүлэг 1

Сэлэнгэ-Энерго ОНӨААТҮГ-ын үйл ажиллагаа нь холбогдох хууль, эрхийн актын хүрээнд, үр нөлөөтэй хэрэгжиж байна уу?

Эрх бүхий албан тушаалтантай үр дүнгийн гэрээ байгуулж, дүгнүүлээгүй байна.

1.1 Үйл ажиллагаа нь холбогдох хууль эрхийн актын хүрээнд үр нөлөөтэй хэрэгжиж байна уу?

Үйлдвэрийн газрын дүрмийг боловсруулж, батлах шаардлагатай байна.

Аймгийн ИТХТ-ийн 2000 оны 60 дугаар тогтоолоор Дулааны станц, шугам сүлжээг Сүхбаатар суманд шилжүүлэн “Сэлэнгэ-Энерго” ОНӨААТҮГ болгон өөрчлөн байгуулжээ.

Гэвч аймгийн ИТХТ-ээс тухайн үйлдвэрийн газрын үйл ажиллагааны чиглэл, байгууллагын дүрэм, бүтэц орон тоо зэргийг боловсруулан батлаагүй байна.

“Сэлэнгэ-Энерго” ОНӨААТҮГ нь 2005 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн 1314001005 дугаарт улсын бүртгэлд бүртгүүлэн, тус үйлдвэрийн газрын захирлын 2012 оны 03 дугаар сарын 07-ны өдөр баталсан дүрмийн дагуу үйл ажиллагааны чиглэлүүдийг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Дүрэмд *“Дулаан үйлдвэрлэх, дулаан түгээх, дулаанаар зохицуулалттай хангах, гадаад дотоод худалдаа, туслах үйлдвэрлэл хөгжүүлэх, гуанз цайны газрын үйлчилгээ”-г* явуулахаар үйл ажиллагааны чиглэлүүдийг тусгасан бөгөөд туслах үйлдвэрлэл хөгжүүлэх, гуанз, цайны газрын үйлчилгээнээс бусад 4 чиглэлийн үйл ажиллагааг явуулахаар улсын бүртгэлд бүртгүүлжээ.

Тус үйлдвэрийн газрын дулаан үйлдвэрлэх түгээх, дулаанаар зохицуулалттай хангах үндсэн үйл ажиллагаа явуулах 10/2014, 11/2014, 12/2014 дугаартай тусгай зөвшөөрлүүдийг 2014 онд Монгол Улсын Эрчим хүчний зохицуулах хорооноос 5 жилийн хугацаатайгаар олгосон байна.

“Сэлэнгэ-Энерго” ОНӨААТҮГ нь нийт суурилагдсан хүчин чадлын 90 орчим хувийг ашиглаж байна.

“Сэлэнгэ энерго” ОНӨААТҮГ нь нийт 5 зуухаар 50 Гкал/цаг дулаан үйлдвэрлэх хүчин чадалтайгаас өнөөгийн байдлаар 1, 3-р зууханд шинэчлэлт хийгдэхээр хүлээгдэж, 2, 4, 5-р зуухаар галлан нийт хүчин чадлын 90 хувийг ашиглаж байна.

2015 онд 70422 Гкал дулаан үйлдвэрлэж, дотоод хэрэгцээнд 5801 Гкал дулаан хэрэглэж, дулааны шугам сүлжээний шугамын алдагдалд 6827 Гкал зарцуулан, 57794 Гкал дулааныг хэрэглэгчдэд борлуулах зэргээр үндсэн үйл ажиллагаагаа үр нөлөөтэй хэрэгжүүлсэн байна.

Тус үйлдвэрийн газар нь 1990 оноос эхлэн 26 дахь жилдээ үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд дулаан үйлдвэрлэлийн үндсэн тоног төхөөрөмжүүдээс /5 зуух, 4 ширхэг сүлжээний насос/ 1, 3-р зууханд 1989 онд ашиглалтад орсноос хойш засвар үйлчилгээ хийгдээгүй, засварын ашиглалтын хугацаа дууссан /1 зуух 15 жилийн ашиглалтын нормтой байдаг/, цаашид ашиглах боломжгүйгээр эвдэрч хэмхрэн, нөөц зуухгүй болсон байна.

2011 онд улсын төсвөөс 2400,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдэж KB-TC-20/150 маркийн зуухыг шинээр суурилуулж ашиглалтад оруулан, 2012 онд 1.2 км урттай ф350-400 мм-н дулааны шугам хоолойг ф400-500 мм болгон өргөтгөсөн бөгөөд 2013 онд улсын төсвийн 1800,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар 1.1 км урттай ф325 мм-ийн шугамыг ф400 мм-ээр, 0.9 км урттай ф219 мм-ийн урттай шугамыг ф377 мм-ийн шугам хоолойгоор тус тус өргөтгөн шинэчилсэн байна.

Аудитын явцад үйлдвэрийн газрын удирдлага, инженер, техникийн ажилтнуудаас асуулга авч, ярилцлага хийхэд цаашид үйлдвэрлэл хэвийн ажиллахын тулд 1, 3-р зуухны шинэчлэлтийг яаралтай хийж 34 Гкал/ цаг-ийн хүчин чадалтай болгох, зуухны орох гарах шугамын өргөтгөлийг хийх, усны алдагдлыг

багасгахын тулд дулаан хуваарилах төвүүдийг тоолууржуулах, ДШС-ний УТ-10-УТ-15 хүртэлх шугамын өргөтгөл, аймгийн нэгдсэн эмнэлгийн урд худгаас төмөр замын дулаан хуваарилах төв хүртэлх ДУ150-н шугамыг ДУ200 болгон өргөтгөх зэрэг ажлуудыг хийх шаардлагатай гэж байлаа.

1.2 Үйл ажиллагааны төлөвлөгөө, үр дүнгийн тайланг холбогдох байгууллагаар хэлэлцэж үнэлэлт, дүгнэлт өгөгдөж байна уу?

Аймгийн ИТХ, Засаг дарга зэрэг холбогдох байгууллага, албан тушаалтны зүгээс тус үйлдвэрийн газрын захиралтай гэрээ байгуулж, дүгнээгүй, үйл ажиллагааны болон санхүүгийн төсөв, төлөвлөгөөг баталж хэрэгжүүлээгүй, үр дүнг үнэлээгүй байна.

ТБОНӨТХуулийн 77 дугаар зүйлд “Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчид, Засаг даргаас орон нутгийн өмчийн хөрөнгийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхээ хэрэгжүүлэх талаар зохиосон ажил, үр ашгийн тайлан, нэгдсэн тооллогын дүнг жил бүр хэлэлцэж, дүгнэлт, чиглэл өгөх эрхтэй” гэж заажээ. Үүний дагуу аймгийн ИТХ-аас “Сэлэнгэ – Энерго” ОНӨААТҮГ-ын 2014 оны үйл ажиллагааны тайланг авч хэлэлцэн 2015 оны 04 дүгээр сарын 22-ны өдрийн 50 дугаар тогтоолоор байгууллагын бүтэц, зохион байгууллалтыг боловсронгуй болгох, үйл ажиллагааны менежментээ сайжруулан зардлаа хэмнэж, өр авлагаа бууруулах талаар идэвх санаачилга гарган ажиллах, иргэд, айл өрх, аж ахуйн нэгж, байгууллагуудад үзүүлж буй үйлчилгээ, бүтээгдэхүүний нэр төрлийг олшруулж, чанар хүртээмжийг дээшлүүлэн хэрэглэгчийн тоог өсгөх замаар ашиг орлогоо нэмэгдүүлэх, цэвэр усны тоолуур суурилуулж бодит хэрэглээгээр өр төлбөрийг тооцох, усны алдагдлыг бууруулах зэрэг үүрэг даалгавруудыг өгсөн ч биелэлт нь хангалтгүй байгаа байгаа бөгөөд 2015 оны эцэст авлага урьд оноос 155.2 сая төгрөгөөр, өглөг 637.0 сая төгрөгөөр, нийт зардал 713.0 сая төгрөгөөр тус тус өсөж, (843,6) сая төгрөгийн алдагдалтай ажилласан дүн мэдээтэй тайлагнагджээ.

Тус үйлдвэрийн газрын захирал нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль¹ болон компанийн дүрэмд² заасны дагуу аймгийн Засаг даргатай гэрээ байгуулж үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө батлуулан мөрдөх ёстой ч гэрээ байгуулдаггүй, үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөөг захирал өөрөө баталж хэрэгжүүлэн иржээ.

1.3 Үндсэн болон санхүүгийн үйл ажиллагаанд дотоод хяналт хийгдэж байна уу?

Үндсэн болон санхүүгийн үйл ажиллагаанд хийгдэх дотоод хяналт сул, үр нөлөө муутай байгаа нь үйлдвэрлэлийн хэвийн үйл ажиллагаа алдагдаж, үйлдвэрлэл, санхүүгийн хүндрэлд орох нэг нөхцөл болж байна.

¹ 19.1 1. Аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын захирлыг / цаашид “захирал” гэх/ томилохдоо гэрээ байгуулна..., 78-р зүйл Орон нутгийн өмчийн талаархи Засаг даргын бүрэн эрх 78.2.2 орон нутгийн өмчит хуулийн этгээдийн эрх баригчийг томилох;

² 7.1 Гүйцэтгэх захирал нь компанийн дүрэм болон аймгийн Засаг даргатай байгуулсан гэрээнд заасан эрх хэмжээний хүрээнд компанийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулна.

2014 онд аймгийн МХГ-ын Санхүү, хөдөлмөр, нийгмийн хамгааллын хяналтын хэлтсээс бусад байгууллагаас ямар нэгэн хяналт шалгалт хийгдээгүй бөгөөд аймгийн Татварын хэлтсийн хяналт шалгалтын тасгаас жил бүр татварын хяналт шалгалт хийж ирсэн байна.

Тус ОНӨААТҮГ-ын санхүүгийн үйл ажиллагаанд аймгийн МХГ-ын Санхүү, хөдөлмөр нийгмийн хамгааллын хяналтын хэлтсээс хяналт шалгалт хийж **зөрчилгүй** гэж дүгнэсэн нь үйлдвэрийн газрын эдийн засаг, санхүүгийн бодит байдалтай нийцэхгүй байгаа бөгөөд дотоод хяналт шалгалт үр нөлөө муутай хийгдэж байгааг харуулж байна.

Эрчим хүчний зохицуулах хорооноос Сэлэнгэ-Энерго ОНӨААТҮГ нь борлуулалтын орлогоороо борлуулсан бүтээгдэхүүний өртгөө нөхөж чадахгүй байгаагаас үүсээд байгаа дулааны алдагдлын шалтгааныг тогтоох, үнийг нэмэгдүүлэх боломжийг судлах зорилгоор 2015 оноос тодорхой хэмжээний хяналт шалгалтыг хийж байгаа ч шалгалтын талаар тайлан, дүн гаргаж, зөвлөмж өгөгдөөгүй байна.

Үйлдвэрийн газрын даргын 2011 оны 09 дүгээр сарын 2-ны 70 дугаар, 2016 оны 03 дугаар сарын 01-ний 12 дугаар тушаалаар Захирлын зөвлөлийг захирал, ерөнхий инженер, хүний нөөц, ерөнхий нягтлан бодогч, ХАБЭА-ын инженер гэсэн удирдах албан тушаалын ажилтнуудын бүрэлдхүүнтэйгээр байгуулан ажиллаж байгаа ч тус зөвлөлийн зүгээс нэг ч удаа байгууллагын үйл ажиллагаа, санхүүгийн чадавхид хяналт хийж үнэлэлт дүгнэлт өгөн, оновчтой бодлого зорилт тодорхойлоогүй, үйлдвэрлэлийн техник, технологийн онцлог, нөхцөл байдлаа бүрэн мэдэж байгаагийн хувьд холбогдох байгууллага, албан тушаалтанд санал хүсэлт гаргаж, тулгамдсан асуудлаа шийдвэрлүүлэх үр нөлөө бүхий арга хэмжээ аваагүй зэрэг нь ч үйлдвэрийн газрын үйл ажиллагааны зардал, алдагдал, авлага, өр төлбөр зэрэг санхүүгийн сөрөг үзүүлэлтүүд сүүлийн жилүүдэд огцом өсөж, өөрийн хөрөнгөөр хэвийн үйл ажиллагаа явуулах нөхцөл боломж алдагдах нэг нөхцөл болсон гэж дүгнэж байна.

Аймгийн ИТХ нь ТБОНӨТХуулийн 77.1 дэх *“ИТХ нь тухайн аймаг, нийслэл, сум дүүргийн өмчийн зүйлсийг хүн амаа төлөөлөн өмчлөгч нь байна”*, 77.2 дахь *“Орон нутгийн өмчийн эд хөрөнгийн хадгалалт, хамгаалалтын байдлыг хянан шалгах буюу түүнд тавих хяналт, шалгалтыг зохион байгуулах”* гэсэн эрхээ бүрэн хэрэгжүүлээгүй, тус үйлдвэрийн газрын техник, технологи хуучирч, санхүүгийн нөхцөл байдал эрс хүндэрсэн байхад удирдлага, зохион байгуулалт, менежментийн ямар ч арга хэмжээ аваагүй байгаа нь ч үйлдвэрийн газрын санхүүгийн хүндрэлийг даамжруулах нэг нөхцөл болжээ.

Иймээс аймгийн ИТХ, Засаг даргын зүгээс эрчим хүчний техник, технологийн мэргэжлийн байгууллага, албан тушаалтнуудыг хамруулан тус үйлдвэрийн газрын үйлдвэрлэл, технологийн байдалд бодит үнэлэлт, дүгнэлт өгөх, шаардлагатай бол дулаан үйлдвэрлэх, түгээх үйл ажиллагааг мэргэжлийн яаманд харьяалуулж, мэргэжлийн удирдлагаар хангуулах, улмаар хуучирсан технологийг шинэчлэх гадаад, дотоодын хөрөнгийн эх үүсвэрийг судалж хэрэгжүүлэх нь зүйтэй юм.

Бүлэг 2

Орлого, зарлагаа үндэслэлтэй төлөвлөж, үр ашигтай ажиллаж байна уу?

“Сэлэнгэ энерго” ОНӨААТҮГ нь үйлдвэрлэл санхүүгийн төлөвлөгөөгөө аймгийн ИТХ-аар батлуулдаггүйгээс гүйцэтгэлд нь хяналт тавьдаггүй бөгөөд айл өрхийн дулааныг бодит өртгөөс нь 8.6 дахин бага үнээр борлуулж байгаагаас алдагдал улам нэмэгдсээр байна.

Оршил

Үйлдвэрийн газрын түвшинд тооцоолсон 2015 оны үйлдвэр санхүүгийн төлөвлөгөөгөөр үндсэн үйл ажиллагааны борлуулалтын орлогыг 3,007.6 сая төгрөгөөр төлөвлөснөөс 3,163.2 сая төгрөг буюу 105.2 хувийн биелэлттэй, ББӨ-ийг 3,678.0 сая төгрөгөөр төлөвлөснөөс 4,165.9 сая төгрөгийн гүйцэтгэлтэй буюу 13.3 хувиар /487.9 сая төгрөгөөр/ хэтрүүлсэн бол ерөнхий удирдлагын зардлыг 218.8 сая төгрөгөөр төлөвлөснөөс 163.6 сая төгрөгийн гүйцэтгэлтэй буюу 74.8 хувийн биелэлттэй, бусад зардал 38.6 сая төгрөгөөр төлөвлөснөөс 33.9 сая төгрөгийн гүйцэтгэлтэй буюу 88.0 хувийн биелэлттэй гарсан байна. Харин тооцоолоогүй бусад орлого 56.7 сая төгрөгийн гүйцэтгэлтэй тайлагнагдаж, өөрөө өөрийгөө санхүүжүүлэн ажиллаж чадахгүйн улмаас орон нутгийн төсвөөс дулааны алдагдлын татаас 300.0 сая төгрөг авсан байна.


“Сэлэнгэ энерго” ОНӨААТҮГ нь үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөөгөө аймгийн ИТХ-аар хэлэлцүүлж, батлуулдаггүй, зөвхөн байгууллагын хүрээнд төлөвлөж байгаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.3 дах “Үйлдвэрийн газрын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулан биелэлтийг хангах” гэсэн заалтыг зөрчиж байна.

2.1 Үйл ажиллагааны орлогыг бүрэн дүүрэн, үндэслэлтэй төлөвлөн төвлөрүүлж байна уу?

Эрх бүхий албан тушаалтнаар санхүүгийн төлөвлөгөөг хянуулж, батлуулдаггүйгээс орлогыг бодитой төлөвлөхгүй байна.

Үйлдвэрийн газрын захирлын баталсан “Сэлэнгэ-Энерго ОНӨААТҮГ-ын 2015 оны үйлдвэрлэл санхүүгийн төлөвлөгөө”-д зөвхөн борлуулалтын орлогыг 3,007.6 сая төгрөгөөр төлөвлөсөн бөгөөд бусад орлогыг төлөвлөөгүй байна.

2015 оны борлуулалтын орлого 3,163.1 сая төгрөг, хүүгийн орлого 0.7 сая төгрөг, бусад орлого 356.0 сая төгрөг зэрэг нийт 3,519.8 сая төгрөгийн орлогын гүйцэтгэлтэй тайлагнагдсан нь урьд оноос 328.9 сая төгрөгөөр өссөн байна.



Үндсэн үйл ажиллагааны орлого урьд оноос 10.1 хувиар өссөн нь төмөр замын орон сууцнуудад 2015 оноос эхлэн хэрэглээний халуун ус түгээдэг болсон, Халамжийн хэлтэс, 3-р сургуулиудын байр ашиглалтад орж дулааны гэрээ байгуулсан, ААНБ-уудын тоо урьд оноос 11.3 хувиар буюу 36-аар, айл өрхийн тоо 11.4 хувиар буюу 43-аар өссөн зэргээс шалтгаалсан бол бусад орлогын хувьд орон нутгийн төсвийн татаас 300.0 сая төгрөг, труба борлуулсны орлого 41.3 сая төгрөг, хоолны орлого 11.1 сая төгрөг, кран ашиглуулсны ажлын хөлс 0.2 сая төгрөг, үйл ажиллагааны бус орлогоор 3.4 сая төгрөг төвлөрүүлсэн байна.

“Сэлэнгэ энерго” ОНӨААТҮГ-ын орлогыг тодорхой түвшинд нэмэгдүүлэх дараах боломж байна гэж үзэж байна. Тухайлбал:

1. Эрчим хүчний зохицуулах хорооны 2015 оны 11 дүгээр сарын 26-ны өдрийн 292 тоот тогтоолоор айл, өрхийн дулааны үнийг 20 хувиар өсгөж 374.2 төгрөг болгосон ч бусад аймгуудын дулааны үнэтэй харьцуулж үзэхэд айл өрхийн хэрэглэгчийн тоо ижил Баянхонгор, Хэнтий зэрэг аймгуудаас 16,8-39,6 хувиар бага байгаа бөгөөд эдгээр аймгийн жишигт хүргэвэл цаашид орлого нэмэгдүүлэх боломж харагдаж байна.

Сэлэнгэ аймагтай ойролцоо дулааны эрчим хүчний хэрэглэгчидтэй аймгуудын дулааны үнийг харьцуулбал:

Хүснэгт №1

№	Нэр	Хэрэглэгчийн тоо		Тариф	
		Айл өрх	ҮААНБ	Айл өрх /төг.м3/	ҮААНБ /төг.м3/
1	Баянхонгор аймаг	2102	128	450	996-1450
2	Булган аймаг	585	278	250-350	876-1900
3	Говьсүмбэр аймаг	1868	153	360	950-1400
4	Дорноговь аймаг	5873	478	350-600	990-1600
5	Дундговь аймаг	1113	144	454	1454
6	Өвөрхангай аймаг	917	215	600	664-907
7	Увс аймаг	1245	176	390-650	900-1300
8	Ховд аймаг	2421	164	200	1350
9	Хэнтий аймаг	1992	122	620-680	760-1650
11	Сэлэнгэ энерго ОНӨААТҮГ /2015.12.31 хүртэл/	2044	300	311.8	1255.8
12	Сэлэнгэ энерго ОНӨААТҮГ /2016.01.01-нээс/	2044	300	374.2	1444.2

Эрчим хүчний сайдын 2015 оны 09 дүгээр сарын 14-ний өдрийн “Халаалтын улирал эхлэх, дуусах хугацааг тогтоох тухай” 122 тоот тушаалын 1.6-д “ Сэлэнгэ, аймгуудын халаалтын эхлэх хугацааг тухайн оны 09 дүгээр сарын 15-ны өдрөөр, дуусах хугацааг дараа оны 05 дугаар сарын 15-ны өдрөөр тогтоосугай” гэж заасан байдаг бөгөөд нийт борлуулалтын орлогын 93,0 хувийг эзэлж байдаг аж ахуйн нэгж, төсөвт байгууллагуудын төлбөрийн чадвараас шалтгаалж халаалтыг 10 сарын 01-нээс авч, 05-р сарын 01-ний өдрөөс зогсоож байна. Иймд дээрх тушаалын дагуу халаалтын хугацааг шийдвэрлэвэл орлого тодорхой түвшинд нэмэгдэх боломжтой гэж үзэж байна.

2.2 Төвлөрсөн орлогыг үр ашигтай, арвилан хэмнэлттэй зарцуулж байна уу?

Үйлдвэрлэсэн дулааныг айл өрхүүдэд 8.6 дахин бага өртгөөр борлуулж 1,960.4 сая төгрөгийн алдагдал хүлээж байгаагаас шалтгаалан ашигтай ажиллах боломжгүй байна.

Удирдлагын зардлын талаар:

Удирдлагын зардал урьд оноос 54.1 сая төгрөгөөр буурсан нь урьд онуудад удирдлагын зардлын бүрэлдэхүүнд ордог байсан харуул хамгаалалтын зардал, зээлийн хүүгийн зардлуудыг 2015 оноос үйлдвэрлэлийн зардалд бүртгэдэг болсонтой холбоотой байна. Удирдлагын зардлын 64,7 хувийг цалин, НДШ-ийн зардал, 15,6 хувийг элэгдлийн зардал, 7,3 хувийг шатахууны зардал, 12,4 хувийг бусад зардал тус тус эзэлж байна.

Хүснэгт № 2

/сая.төг/

№	Зардлын ангилал	2014 он	2015 он	Өсөлт
1	Ажиллагчдын цалингийн зардал	66.1	93.6	27.4
2	НДШ	37.6	12.2	(25.5)
3	Томилолтын зардал	0.1	0.4	0.4
4	Бичиг хэргийн зардал	1.8	0.0	(1.8)
5	Шуудан холбооны зардал	0.3	0.6	0.3
6	Элэгдэл, хорогдлын зардал	25.3	25.6	0.3
7	Харуул хамгаалалтын зардал	23.2	-	(23.2)
8	Тээврийн зардал	9.5	1.0	(8.6)
9	Шатахууны зардал	13.4	12.1	(1.3)
10	Линзит ашигласны төлбөр	1.7	1.7	-
11	Зар сурталчилгааны зардал	2.1	2.8	0.7
12	Зээлийн хүүгийн зардал	29.7	-	(29.7)
13	Шагнал урамшууллын зардал	5.9	4.6	(1.4)
14	Бусад зардал	0.9	9.1	8.2
Нийт удирдлагын зардал		217.7	163.6	(54.1)

Борлуулсан бүтээгдэхүүний өртөг, зарцуулалтын талаар:

ББӨ-ийн хувьд 31% буюу 1,289.4 сая төгрөгийг нүүрсний зардал, 11% буюу 464.3 сая төгрөгийг цахилгааны зардал, 10% буюу 303.4 сая төгрөгийг усны зардал, 22% буюу 878.0 сая төгрөгийг цалингийн зардал, 2,7% буюу 114.1 сая төгрөгийг НДШ-ийн зардал, 8,9% буюу 372.5 сая төгрөгийг элэгдлийн зардал, 1,6% буюу 67.6 сая төгрөгийг зээлийн хүүгийн зардал, 2,4% буюу 100.8 сая төгрөгийг шатахууны зардал, 6,2% буюу 258.8 сая төгрөгийг урсгал засварын зардал, 4,2%-ийг буюу 317.0

сая төгрөгийг бусад зардал эзэлж байна.

Хүснэгт №3

/сая.төг/

№	Зардлын төрөл	2014 он	2015 он	Өсөлт
1	Нүүрсний зардал /тээврийн зардал/	1,049.6	1,289.5	239.9
2	Усны зардал	276.7	303.5	26.8
3	Цахилгааны зардал	351.6	464.3	112.7
4	Шатахууны зардал	80.4	100.8	20.4
5	Сэлбэг хэрэгсэл урсгал засвар	226.9	258.8	31.9
6	Үндсэн ба нэмэгдэл цалин	737.1	878.0	140.9
7	Байгууллагаас төлөх ЭМ, НДШ	96.8	114.1	17.3
8	Элэгдэл зардал	340.6	372.5	31.9
9	Зээлийн хүүгийн зардал	11.1	67.6	56.5
10	Бусад зардал	223.2	316.8	93.6
	ББӨртгийн дүн	3,394.0	4,165.9	771.9

“Сэлэнгэ энерго” ОНӨААТҮГ-ын 2015 оны борлуулсан бүтээгдэхүүний өртөг өмнөх оноос 771.9 сая төгрөгөөр буюу 22,7%-иар өссөн нь дараах шалтгаануудтай байна. Үүнд:

- Дулаан үйлдвэрлэлийн хэмжээ урьд оноос 2,322 Гкал-аар нэмэгдсэн;
- Гол түүхий эд болох 1 тн нүүрсний үнэ 57,6-72,7 хувиар, цахилгааны үнэн дээр чадлын тариф, дэмжих тарифууд нэмэгдсэн;
- Сүхбаатар сумын ихэнх орон сууцнуудын инженерийн шугам сүлжээ муудсанаас усны алдагдал ихсэж усны төлбөрийн зардал өссөн.

2015 онд 70422 Гкал дулаан үйлдвэрлэж, 5801 Гкал дулааныг дотооддоо хэрэглэж, 6827 Гкал дулаан шугамын алдагдал гаргаж, 57794 Гкал дулаан борлуулсан бөгөөд дулаан үйлдвэрлэлийн хэмжээ 2008 оноос хойш 3,3-19,1 хувиар нэмэгдсэн байна.

Хүснэгт № 4

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	Оны гүйцэтгэлүүд							
			2008	2009	2010	2011	2012	2013	2014	2015
1	Боловсруулсан дулаан	Гкал	56979	63656	67569	61963	62258	57407	68100	70422
2	Дотоод хэрэглээний дулаан	Гкал	4109	6215	5880	2980	3506.4	4018	5200	5801
		%	7.2	9.8	8.7	4.8	5.6	7	8.1	8.2
3	Түгээсэн дулаан	Гкал	52870	57441	61689	58983	58751.6	53389	63000	64621
4	Шугамын алдагдал	Гкал	5695	4260	4490	4500	4500	2200	4544	6827
		%	10.8	7.4	7.3	7.6	7.7	4.2	7.2	10.6
5	Борлуулсан дулаан	Гкал	47175	53181	57199	54483	54251.6	51189	58460	57794

Цахилгааны үнэн дээр чадлын тариф, дэмжих тариф нэмэгдсэнээр 2015 онд нийт 464.3 сая төгрөгийн цахилгааны зардал гарч урьд оноос 112.7 сая төгрөгөөр өссөн бол 1 тн нүүрсний үнэ урьд оноос 57,6-72,7 хувиар нэмэгдэж нүүрсний зардал 2015 онд 704.8 сая төгрөгийн гүйцэтгэлтэй гарч өмнөх оноос 387.8 сая төгрөгөөр өссөн байна. Өөрөөр хэлбэл, тус үйлдвэрийн газар нь жилд 30.0-35.0 мянган тонн нүүрс хэрэглэдэг бөгөөд 2011-2014 онуудад “Рэдхилл Монголиа” ХХК-ний Улаан-Овоотын уурхайгаас тээврийн зардал ороод 1 тн нүүрсийг 33.0 мянган

төгрөгөөр худалдан авч байсан бол уг уурхайн олборлолт зогсож, чанарын шаардлага хангахгүй, илчлэгээ алдсан, 2-3 жил өнжсөн нүүрсийг худалдан авах боломжгүй болсон тул Олон-Овоотын уурхайгаас 1 тн нүүрсийг тээврийн зардал ороод 52.0-57.0 мянган төгрөгөөр худалдан авч байгаа нь нүүрсний зардлыг ихээр өсгөсөн байна.

Сүхбаатар сумын айл, өрхүүд дулааны шугамын холболтыг норм, стандартын дагуу хийхгүй байгаатай холбоотойгоор дулааны алдагдал жилээс жилд өссөн байна. Иймд холбогдох мэргэжлийн байгууллагуудаас дулааны шугам тавих явцад хяналт тавьж, холболтыг норм нормативын дагуу хийлгэх шаардлагатай байна.

Аудитын явцад хөрөнгийн зарцуулалттай холбоотой дараах зөрчлүүд илэрлээ. Үүнд:

- Үйлдвэрийн газрын хэвийн үйл ажиллагаа алдагдаж, татвар, НДШ-ийн их хэмжээний өглөг үүссэнээс болж харилцах дансаар орж ирсэн орлогыг холбогдох байгууллагаас данс хаах замаар шууд татаж авдагаас шалтгаалан 2015 онд мөнгөн хөрөнгийн зарлагын гүйлгээний 45,0 хувь нь кассаар дамжин хийгдсэн нь мөнгөн хөрөнгийн зарцуулалтад бүртгэлээр тавих хяналт сулрах, анхан шатны баримтгүй ажил гүйлгээ гарах, үр ашиггүй зардал гарах эрсдлүүдийг бий болгож байна.
- 2015 онд зайлшгүй хэрэгцээ шаардлага үүсээгүй, мэргэжлийн сонин сэтгүүл бус Монголын Залуучуудын холбооноос гаргасан сонин сэтгүүлийн хэвлэл захиалга **1,000.0** мянган төгрөгийн, ажилчдын аялал зугаалгад **7,229.0** мянган төгрөгийн зардал гаргасан нь үйлдвэр алдагдалтай ажиллаж байгаа өнөөгийн нөхцөлд үр ашиггүй зардал болсон байна.

Үйл ажиллагааны ашиг, алдагдлын талаар:

“Сэлэнгэ-Энерго” ОНӨААТҮГ нь үйлдвэрлэсэн дулааныг алдагдалтай борлуулдаг, техник технологийн шинэчлэл хийгдээгүй зэрэг нь алдагдалтай ажиллах нэг нөхцөл болж байна.

Үйлдвэрийн газар алдагдалтай ажиллахад дараах шалтгаанууд голлон нөлөөлсөн байна. Үүнд:

1. Нийт түгээж байгаа дулааны 60,0 хувийг хэрэглэж байгаа айл, өрхөд дулааныг өртгөөс нь хэт бага үнээр борлуулж, энэ нь нийт борлуулалтын дөнгөж 7,0 хувийг эзэлж байгаа нь алдагдал хүлээх үндсэн шалтгаан болж байна.

Өөрөөр хэлбэл, 1 Гкал дулааныг 64,467 төгрөгөөр үйлдвэрлэж, айл өрхөд 7,480 төгрөгөөр буюу өртгөөс нь 8,6 дахин бага үнээр борлуулж, нийт 1,960.4 сая төгрөгийн алдагдал хүлээж байна.

Хүснэгт №5

/сая.төг/

д/д	Үзүүлэлт	Түгээсэн дулааны бүтэц		1Гкал дулааны		Халаалтын орлогын бүтэц		Ашиг/ Алдагдал
		Гкал	%	Өртөг	Үнэ	сая.төг	%	сая.төг
1	Төсвийн байгууллага	14244	25.0	64467	142495	2,029.7	65.0	1,111.43
2	ААНБайгууллага	9150	15.0	64467	95855	877.1	28.0	287.20
3	Айл өрхүүд	34400	60.0	64467	7480	256.3	7.0	(1,960.35)
дүн		57794	100			3,163.1	100	

- УТ-10-УТ-15 хүртэлх шугамд дулааны өртөгтөгөл хийгдээгүй, үүнээс шалтгаалан дулаан хуваарилах төв-3 дээр нэмэлт өргөлтийн насос ажиллуулж байгаа зэрэг шалтгааны улмаас 2015 онд нүүрсний зарцуулалт 1761 тн-оор илүү буюу дундаж ханшаар тооцвол 57.2 сая төгрөгөөр, цахилгааны зардал 286464 квт-аар илүү буюу 36.8 сая төгрөгөөр, станцын хэрэглэсэн нэмэлт усны хэмжээ 46876 М3-ээр илүү буюу 106.4 сая төгрөгөөр зэрэг нийт төлөвлөсөн хэмжээнээс **200.4** сая төгрөгөөр илүү зардал гаргасан байна.
- 2015 онд нүүрсний илчлэг өндөр гэсэн шалтгаанаар “Ред хилл Монголиа” ХХК-аас 1-3 сарын хооронд гэрээний дагуу 1тн-ыг нь 11,0 мянган төгрөгөөр /нөөт-тай/ худалдаж авч байсан бол 4-8 сарын хооронд тээврийн зардлыг оруулаад 60,0-60,0 мянган төгрөгөөр худалдан авч, **7.6** сая төгрөгийн нэмэлт зардал гаргасан.

“Ред хилл Монголиа” ХХК-аас 2015 онд худалдан авсан нүүрсний тооцоо

Хүснэгт № 6

Сар	Байгууллагын нэр	Худалдан авсан нүүрс ТН	Нэгжийн үнэ /мян.төг/	Нийт дүн /нөөттэй/
1	РЕД ХИЛЛ Монголиа ХХК	8915.25	11000	98.1
2	РЕД ХИЛЛ Монголиа ХХК	5115.45	11000	56.3
3	РЕД ХИЛЛ Монголиа ХХК	267.95	11000	2.9
4	РЕД ХИЛЛ Монголиа ХХК	60	63000	3.8
5	РЕД ХИЛЛ Монголиа ХХК	39.84	63000	2.5
6	РЕД ХИЛЛ Монголиа ХХК	60	60000	3.6
7	РЕД ХИЛЛ Монголиа ХХК	117.42	60000	7.0
8	РЕД ХИЛЛ Монголиа ХХК	10	60000	0.6
Нийт дүн		14585.91		174.8

- “Сэлэнгэ-Энерго” ОНӨААТҮГ нь үйлдвэр, санхүүгийн төлөвлөгөө батлахдаа ашигтай бус харин 933.0 сая төгрөгийн алдагдалтай төлөвлөж, өөрөөр хэлбэл үйл ажиллагаагаа өөдрөгөөр харж төлөвлөөгүй, ашигтай ажиллах нөхцөлгүй гэж үзсэн байхад холбогдох байгууллагын зүгээс үйлдвэрлэл санхүүгийн төлөвлөгөөг хянаж батлаагүй, цаашид нэмэлт орлого олох, зардлыг бууруулах, үр ашгийг нэмэгдүүлэх арга замыг тодорхойлоогүй байна.

Цаашид дулаан хуваарилах төв бүр дээр усны тоолуур тавих, дулааны шугамын өргөтгөлийг бүрэн хийж дуусгах, үйлдвэрлэлийн хүчин чадлын хүрээнд эдийн засгийн тооцоог нарийвчлан хийж, дулааны үнийг шат дараатай, зардлаа

нөхөх түвшинд хүргэхгүй бол алдагдал улам ихсэж, үйлдвэрлэлийн үйл ажиллагаа зогсох магадлал өндөр байна.

2.3 Авлага, өглөгийг барагдуулж, үр ашигтай ажиллаж байгаа эсэх?

“Сэлэнгэ энерго” ОНӨААТҮГ нь төлбөрийн чадваргүй, санхүүгийн тогтворгүй байдал үүссэн зэргээс бие даан үйл ажиллагаа явуулах боломжгүй байдалд хүрсэн байна.

2015 онд төсвийн байгууллагуудаас 171.8 сая төгрөг, ААНБ-уудаас 180.2 сая төгрөг, айл өрхөөс 115.2 сая төгрөг, бусад 19.4 сая төгрөг, нийт **486.6 сая төгрөгийн авлагатай**, усны төлбөрт 520.2 сая төгрөг, цахилгааны төлбөрт 160.7 сая төгрөг, НДШ-д 215.6 сая төгрөг, нүүрсний төлбөрт 534.6 сая төгрөг, банкны зээл 319.6 сая төгрөг, төрийн сангийн хуримтлагдсан өглөг 744.5 сая төгрөг, татварын өглөг 290.5 сая төгрөг, бусад өглөг 168.3 сая төгрөг зэрэг нийт **2,954.0 сая төгрөгийн өглөгтэй** гарсан бол 2016 оны 1 улирлын байдлаар 803.9 сая төгрөгийн авлага, 3,277.7 сая төгрөгийн өглөгтэй тайлагнагдаж, үйл ажиллагаа явуулах тусам авлага, өглөг өсөх сөрөг чиг хандлагатай болсон байна.

Авлагыг насжилтаар нь харуулбал:

Хүснэгт № 7

/сая.төг/

д/д	Дансны зориулалт	2014 он авлага	2015 он авлага	1жил	1жилээс дээш
1	Дансны авлага	1.20	2.00	2.00	
2	Дулааны ААНБайгууллагын	112.70	180.20	125.20	55.00
3	Төвлөрсөн орон сууцны	87.00	99.80	83.40	16.40
4	Хувийн орон сууцны авлага	12.40	15.40	11.10	4.30
5	Төсөвт байгууллагын авлага	114.10	171.80	59.50	112.30
Бүлгийн дүн :		327.40	469.20		
7	Ажилчдаас авах авлага	4.00	17.40	17.40	
8	Хувь хүмүүсээс авах авлага	0.04	0.06	0.06	
Бүлгийн дүн :		4.04	17.46		
Нийт авлагын дүн		331.4	486.7	298.7	188

Ажилчдаас авах авлагуудын ихэнхийг сургалтын төлбөрийн зээл, скайтелийн гар утас, хүнсний материал зэргийг зээлээр олгосон, цалингийн урьдчилгааг дутуу суутгасантай холбоотой авлагууд эзэлж байгаа нь тухай бүрт нь барагдуулах боломжтой авлага гэж үзэж байна. Мөн улс оронд үүсээд байгаа эдийн засгийн хямралтай холбоотойгоор төсвийн байгууллагуудын санхүүжилт дутуу тавигдсан, хувийн ААНБ-уудын хэвийн үйл ажиллагаа доголдсон зэргээс шалтгаалан төсөвт байгууллага, ААНБ-уудын дулааны авлага урьд оноос 57.7-67.5 сая төгрөгөөр өссөн нь нийт авлага 46.9 хувиар өсөхөд голлох нөлөө үзүүлсэн байна.

Аж ахуйн нэгж, байгууллагын нийт дулааны авлагын 78,9 хувийг 3-р сургууль, 2-р сургууль, Онцгой байдлын хэлтэс, Өсөх урам зах / Сүхбаатар шинэ зах / зэрэг төр, төсвийн байгууллагуудуудын авлага эзэлж байгаа бөгөөд үүнээс 112.3 сая

төгрөгийн авлага хугацаа хэтэрсэн байгааг аймаг, орон нутгийн удирдлагууд анхааралдаа авч барагдуулах талаар арга хэмжээ авах шаардлагатай байна.

Хүснэгт №8

/сая.төг/

№	Байгууллагын нэр	Авлагын дүн
1	1-р сургууль	7.72
2	2-р сургууль	14.27
3	4-р сургууль	7.15
4	МСҮТөвийн дотуур байр	4.43
5	Аймгийн төв номын сан	0.69
6	Онцгой байдлын хэлтэс	14.75
7	ЗООНОЗ төв	0.85
8	Мах боловсруулах үйлдвэр	5.06
9	Сүхбаатар сумын байр	5.53
10	Нийгмийн халамж үйлчилгээ- Хялганат Нуга	4.33
11	Шинэ 3-р сургууль	97.57
12	Нутгийн захиргааны 2-р байр	0.68
13	Өсөх урам зах шинэ	10.15
Авлагын нийт дүн		173.18

2015 онд авлага барагдуулах талаар тодорхой арга хэмжээ авч ажилласан ч төдийлөн үр дүн гараагүй байна. Тухайлбал:

- 44 хэрэглэгчийг шүүхэд өгснөөс 37 айл өрх, 7 ААНБ-ын 80.9 сая төгрөгөөс 67.3 сая төгрөгийг төлүүлсэн
- Орон нутгийн кабелийн телевизэд 12 удаа өр барагдуулах талаар зар явуулсан
- Айл өрх, албан байгууллагуудад 92.9 сая төгрөгийн авлага барагдуулах мэдэгдэх хуудсыг 185 удаа өгч авлага барагдуулах талаар шаардсан.
- Захирлын 2014 оны 67 тоот тушаалаар батлагдсан журмын дагуу борлуулалтын байцаагч нарын ажлыг сар бүр дүгнэж авлага барагдуулаагүй байцаагчийн үр дүнгийн цалинг бууруулах арга хэмжээ авч ажилласан.

Гэвч 2015 оны авлага урьд оноос 155.2 сая төгрөгөөр, 2016 оны 1-р улирлын байдлаар авлага 2015 оноос 317.2 сая төгрөгөөр өссөн үзүүлэлттэй байгаа нь цаашид авлага барагдуулах ажлыг өргөн цар хүрээтэй, үр дүнтэй зохион байгуулах шаардлагатай байгааг харуулж байна.

Өглөгийг насжилтаар нь авч үзвэл:

Хүснэгт № 9

/сая.төг/

Д/Д	Байгууллага нэр	2012 он	2013 он	2014 он	2015 он	1жил Хугацаа хоног	1-ээс дээш Насжилт Хугацаа хоног	5-ээс дээш Насжилт Хугацаа хоног
1	Урсгал ус ХХК усны	195.9	385.3	519.1	520.2	303.4	216.7	

2	Цахилгаан	18.5	18.7	35.6	160.7	160.7		
3	НДШимтгэл	23.7	97.0	121.3	215.6	94.3	121.3	
4	Татвар	74.3	123.1	177.3	290.5	128.8	161.7	
7	Банкны зээл, хүү Төрийн банк	73.0	266.7	166.7	319.6	319.6		
8	Нүүрс	496.3	367.5	507.4	534.6	534.6		
12	Бүрэндүлаан ХХК эрчим хүчний татаас				33.8	33.8		
13	бусад өглөг	118.9	86.3	44.4	134.6	134.6		
14	ӨГЛӨГИЙН ДҮН	1,000.6	1,344.6	1,571.8	2,209.6			
15	Төр санд зээлийн өглөг /2004 оноос хойшхи нүүрсний өр /	798.4	744.5	744.5	744.5			744.5
16	Өглөгийн нийт дүн	1,799.0	2,089.1	2,316.3	2,954.1	1,709.8	499.7	744.5

Дээрх хүснэгтээс харахад 2012 оноос эхлэн жил бүр усны төлбөрийн өглөг 1,3-2 дахин, цахилгааны өглөг 1,9-4,5 дахин, урьд оноос банкны зээлийн өр 91,7 хувиар, НДШ-ийн өглөг 77,7 хувиар, татварын өглөг 63,8 хувиар тус тус өссөн бөгөөд 2015 оны нийт өглөгийг насжилтаар задалбал 57,9 хувь нь 1 жил хүртэлх, 16,9 хувь нь 1-5 хүртэлх насжилттай өглөг байгаа бол 25,2 хувь нь 2004 оноос эхэлсэн, он удаан жилийн барагдаагүй өглөг байна. Өглөг урьд оноос 27,7 хувиар буюу 637.8 сая төгрөгөөр өсөхөд үйлдвэрлэсэн дулааны хэмжээ урьд оноос 2,322.0 мянган Гкал-аар өссөн, үйлдвэрийн гол түүхий эд болох нүүрсний үнэ 57,6-72,7 хувиар өссөн, цахилгааны үнэн дээр чадлын тариф, дамжих тарифууд нэмэгдэж төлбөр өссөн, Сүхбаатар сумын ихэнх орон сууцнуудын инженерийн шугам сүлжээ муудсанаас усны алдагдал ихэссэн, айл өрх, орон сууцанд түгээж байгаа дулааныг өртөгөөс нь 8,6 дахин бага үнээр борлуулж байгаа зэрэг нь голлон нөлөөлсөн байна.

2016 оны 1-р улирлын байдлаар өглөг 2015 оноос 323.6 сая төгрөгөөр буюу 10,9 хувиар өссөн байна.

Цаашид өр авлага бууруулах ажлыг үр дүнтэй зохион байгуулж, насжилт ихтэй авлагуудыг хууль, хяналтын байгууллагад шилжүүлж шийдвэрлүүлэх, орон нутгийн холбогдох байгууллагуудтай хамтран ажиллаж ААНБ, төсвийн байгууллагуудад борлуулсан борлуулалтын орлогын авлагыг бууруулах талаар тодорхой арга хэмжээнүүдийг авч ажиллах шаардлагатай байна.

Үр ашигт ажиллагааны талаар:

Сангийн сайдын 2013 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн 277 дугаар тушаалаар ААНБ-ын “Санхүүгийн тайланд шинжилгээ хийх үлгэрчилсэн заавар”-ыг баталсан бөгөөд бид аудитын явцад тус зааврын холбогдох үзүүлэлтүүдээр “Сэлэнгэ энерго” ОНӨААТҮГ-ын сүүлийн 3 жилийн санхүүгийн тайланд шинжилгээ хийлээ.

Хүснэгт № 10

№	Шинжилгээний төрөл	2013 он	2014 он	2015 он
Нэг. Төлбөрийн чадварын шинжилгээ				
1.1	Цэвэр эргэлтийн хөрөнгө	(1,335.00)	(1,581.00)	(1,878.70)
1.2	Түргэн хөрвөх хөрөнгийн харьцаа	0.14	0.17	0.19
1.3	Эргэлтийн харьцаа	0.27	0.26	0.29
1.4	Эргэлтийн хөрөнгийн хувийн жин	0.09	0.09	0.12
1.5	Цэвэр эргэлтийн хөрөнгийн хувийн жин	(2.74)	(2.78)	(2.49)
1.6	Төлөгдөх хугацаа хэтэрсэн өр төлбөрийн хувийн жин			0.42
Хоёр. Санхүүгийн тогтвортой байдлын шинжилгээ				
2.1	Бие даах чадварын коэффициент	0.63	0.65	0.54
2.2	Санхүүгийн хамаарлын коэффициент	1.59	1.54	1.85
2.3	Зохицуулалтын коэффициент	(0.38)	(0.37)	(0.54)
2.4	Өр төлбөрийн хувийн жин	0.37	0.35	0.46
2.5	Урт хугацаат зээл болон эздийн өмчийн харьцаа	0.08	0.04	0.09
2.6	Өр төлбөр ба эздийн өмчийн харьцаа	0.59	0.54	0.85
Гурав. Бүтээмжийн шинжилгээ				
3.1	Хөдөлмөрийн бүтээмж	(9.23)	(3.83)	(7.03)
3.2	Үндсэн хөрөнгийн ачаалал	0.50	0.48	0.56
3.3	Эдийн засгийн тогтвортой өсөлт	(0.32)	(0.11)	(0.24)
Дөрөв. Ашигт ажиллагааны шинжилгээ				
4.1	Борлуулалтын ашигт ажиллагаа	(0.43)	(0.16)	(0.27)
4.2	Хөрөнгийн ашигт ажиллагаа	(0.20)	(0.07)	(0.13)
4.3	Эздийн өмчийн ашигт ажиллагаа	(0.32)	(0.11)	(0.24)

Шинжилгээний дүнгээс үзэхэд:

- Цэвэр эргэлтийн хөрөнгөөрөө богино хугацаат өр төлбөрөө барагдуулж чадахгүй болсон, түргэн хөрвөх хөрөнгөөрөө богино хугацаат өр төлбөрийнхөө зөвхөн 14,0-19,0 хувийг, нийт эргэлтийн хөрөнгөөрөө 26,0-29,0 хувийг л барагдуулах боломжтой, нийт өрийн 42,0 хувь нь хугацаа хэтэрсэн нь **төлбөрийн чадвар муу** болохыг,
- Нийт хөрөнгөнд эзлэх өөрийн хөрөнгийн хэмжээ урьд онуудаас 9,0-11,0 хувиар буурсан, нийт өр төлбөрийн нийт хөрөнгөнд эзлэх хувь 46,0 хувьд, өөрийн хөрөнгөнд /Эздийн өмч/ эзлэх хувь 85,0 хувьд хүрсэн нь **санхүүгийн тогтворгүй байдал үүссэн** болохыг,
- Алдагдалтай ажиллаж байгаагаас нэг хүнд ногдох хөдөлмөрийн бүтээмж (-) үзүүлэлттэй, эдийн засгийн тогтвортой өсөлтийн коэффициент буюу өөрийн хөрөнгийн 1 төгрөгт ногдох ашиг мөн л (-) үзүүлэлтэй гарч, сүүлийн 3 жил буюу 2013 онд (1,107,429.4) мянган төгрөгийн, 2014 онд (459,425.2) мянган төгрөгийн, 2015 онд (843,602.4) мянган төгрөгийн алдагдалтай ажилласан нь ашигт ажиллагааг сөрөг үзүүлэлттэй гаргаж байна.

Өөрөөр хэлбэл тус үйлдвэрийн газар нь санхүүгийн үзүүлэлтийн хувьд төлбөрийн чадваргүй, санхүүгийн тогтворгүй байдал үүссэн, цаашид **бие даан үйл ажиллагаа явуулах боломжгүй байдалд хүрсэн байна** гэж дүгнэж байна.

Бүлэг 3

Хөрөнгийн худалдан авалт, ашиглалт, зарцуулалт арвилан хэмнэлт, үр ашигтай байна уу?

Хөрөнгийн худалдан авалтыг хуулийн дагуу зохион байгуулаагүй байна.

3.1 Худалдан авах ажиллагааг холбогдох хууль, эрхийн актын хүрээнд зохион байгуулж байна уу?

“Сэлэнгэ Энержо” ОНӨААТҮГ нь худалдан авах ажиллагаанд холбогдох хууль, дүрэм, журмыг мөрдөөгүй байна.

2015 онд ТБОНӨХБАУХА тухай хуулийн 8.1.1³, ЗГ-ын 2013 оны 68 дугаар тогтоолоор батлагдсан Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагаанд мөрдөх журмыг сонгоход баримтлах босго үнэ⁴-ээс давсан нийт 12 төрлийн 968.3 сая төгрөгийн, 2016 оны эхний улиралд 4 төрлийн 659.3 сая төгрөгийн худалдан авалтыг хийжээ. Хэдийгээр нүүрсний 704.8 сая төгрөгийн, шатахууны 117.2 сая төгрөгийн худалдан авалтыг нээлттэй тендер шалгаруулалтын журмаар, бусад худалдан авалтыг харьцуулалтын аргаар гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ёстой ч дээрх худалдан авалтуудыг шууд гэрээ байгуулах аргаар гүйцэтгэжээ.

Хүснэгт № 11

Код	Материалын нэр	Х/н	2015 он		2016 оны 4 сар	
			Тоо хэмжээ	Дүн /сая төг/	Тоо хэмжээ	Дүн /сая төг/
1	Нүүрс	Тонн	31,642	704.79	18,279	595,0
2	Галын тоосго	Ширхэг	3,000	13.50		
3	Давс	тонн	95,7	42.82		
4	Труба ф - 219	Метр	234	11.70		
5	Труба ф51	Метр	1,980	14.85		
6	Трубаф20	Метр	3,858	19.25		
7	А-80	Литр	17,129	27.27	19,626	29.08
8	Бензин АИ-92	Литр	8,452	14.87	4,825	7.61
9	Дизель түлш	Литр	39,924	75.03	16,170	27.66
10	Ул ширэм	Ширхэг	300	15.00		
11	Үхрийн мах	тонн	2,7	19.07		
12	Шопол дэр мод	Ширхэг	166	10.13		
Нийт дүн				968.28		659.35

2015 онд шууд худалдан авалтын босго үнээс давсан дараах худалдан авалтуудын гүйцэтгэгчийг хуулийн дагуу сонгон шалгаруулаагүй байна. Үүнд:

- “Мөнхийн эгшиг” ХХК-аас /захирал Ц.Бямбацогт/ ф51-ийн труба 1980 м-ийг 14.9 сая төгрөгөөр, 3000 ширхэг галын тоосгыг 13.5 сая төгрөгөөр,

³ Харьцуулалтын аргаар худалдан авч болох бараа, ажил, үйлчилгээний төсөвт өртгийн дээд хязгаар

⁴ 2 дахь заалт Шууд худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаар бараа 10 сая төгрөг

- “Зочу Сэлэнгэ” ХХК-аас /захирал М.Суурьбат/ ф219-ийн труба 234 м-ийг 11.7 сая төгрөгөөр, ул ширэм 300 ширхэгийг 15.0 сая төгрөгөөр,
- “Сэлэнгэ барилга” ХХК-аас /захирал Б.Баяртогтох/ ф-20-ийн труба 3800 м-ийг 19.0 сая төгрөгөөр,
- “Долгион Алтанбулаг” ХХК-аас /захирал Ц.Базарсүрэн/ 60 тн давсыг 27.0 сая төгрөгөөр, иргэн Б.Буянцогтоос 30.7 тн давсыг 13.8 сая төгрөгөөр тус тус шууд худалдан авсан байна.

Мөн “Редхилл Монголиа” ХХК-аас нүүрс тээвэрлэлт хийсэн **320.5** сая төгрөгийн ажлын гүйцэтгэчийг нээлттэй тендер шалгаруулалтын журмаар сонгон шалгаруулах ёстой ч “Эрдэнэт Ивээл” ХХК, Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын 4-р багийн иргэн Даваасүрэнгийн Ууганбаяр нартай шууд гэрээ байгуулан гүйцэтгүүлжээ. Тээвэрлэлтийн хөлсийг 1 тн-ийг 22.0 мянган төгрөгөөр тооцож гэрээ байгуулсан бөгөөд 2015 онд “Эрдэнэт Ивээл” ХХК-аар 4.5 мянган тн нүүрс тээвэрлүүлж 100.4 сая төгрөг, иргэн Д.Ууганбаяраар 10.0 мянган тн нүүрс тээвэрлүүлж 220.1 сая төгрөгийн ажил тус тус гүйцэтгүүлсэн байна.

Үйлдвэрлэлийн гол түүхий эд болсон нүүрс, шатахуун, сэлбэг хэрэгсэл, давс зэргийн худалдан авалт, нүүрс тээвэрлэлтийн гүйцэтгэчийг холбогдох хууль эрхийн актын дагуу үнийн харьцуулалтыг хэрэглэлгүйгээр шууд сонгосон болон гүйцэтгэчийг сонгон шалгаруулах тендерийн болон үнэлгээний хороо байгуулалгүйгээр удирдлагын ганцаарчилсан шийдэрээр шууд худалдан авалтын аргыг хэрэглэж байгаа зэрэг нь үйлдвэрлэлийн өртөг, зардлыг өсгөж, алдагдалтай ажиллах нэг нөхцөл болсноос гадна ашиг, сонирхлын зөрчил үүсгэх эрсдлийг дагуулж байна гэж дүгнэж байна.

2015 оны нүүрсний худалдан авалт, зарцуулалтыг нарийвчлан авч үзвэл:

- Үйлдвэрлэлийн гол түүхий эд болох нүүрсийг 2015 онд дараах газруудаас худалдан авсан байна. Үүнд:

“Сэлэнгэ гүүр” ХХК, “РЕД ХИЛЛ Монголиа” ХХК, “Багануур” ХХК, “Чингисийн хар алт” ХХК, “Багануур илч” ХХК, УБТЗ-ын Сүхбаатар өртөө зэрэг газруудаас нийт 704.8 сая төгрөгийн 31641.61 тн нүүрс худалдан авсан бол 2016 оны эхний улирлын байдлаар “Чингисийн хар алт” ХХК, “Шарын голын уурхай”, “Экопартнерс” ХХК, “Багануур” ХХК-иудаас 489.7 сая төгрөгийн 15629.67 тн нүүрс худалдан авчээ.

Хүснэгт № 12

/сая.төг/

№	Харилцагч байгууллагын нэр	Нийт хүлээн авсан нүүрс /тн/	Нэгжийн дундаж үнэ /нөөт-тэй/	Нийт орлого /сая.төг/	Гэрээ байгуулсан эсэх
2015 он					
1	РЕД ХИЛЛ Монголиа ХХК	14,585.9	11.0-63.0	174.8	тийм
2	Сэлэнгэ гүүр ХХК	220.0	35.7	7.9	тийм
3	Багануур ХХК	3,252.0	35.7	116.3	тийм
4	Багануур илч ХХК	2,177.8	39.4	85.8	тийм
5	Олон овоо	191.3	25.9	5.0	тийм
6	Чингисийн хар алт ХХК	11,161.6	28.0	312.5	тийм

7	УБТЗам	53.0	49.0	2.6	үгүй
	дүн	31,641.6		704.8	
<i>2016 оны 1-р улирал</i>					
1	Чингисийн хар алт ХХК	11,378.0	28.0	318.6	тийм
2	Экопартнерс ХХК	70.0	81.3	5.7	үгүй
3	Шарын голын уурхай	73.5	50.1	3.7	үгүй
4	Багануур ХХК	4,108.2	39.4	161.8	тийм
	дүн	15,629.7		489.7	

Гэрээ байгуулалгүйгээр “Шарын голын уурхай”-аас 3.7 сая төгрөгийн /73,52тн*50.0 мян.төг/, нүүрс олборлох үйл ажиллагаа явуулдаггүй “Сэлэнгэ гүүр”ХХК-иас 7.8 сая төгрөгийн /220тн*35.7 мян.төг/, “УБТЗ-ын Сүхбаатар өртөө”-гөөс 2.6 сая төгрөгийн /53тн*49.0мян.төг/, “Экопартнерс”ХХК-аас 5.7 сая төгрөгийн /70тн*81.3 мян.төг/ нүүрс тус тус худалдан авсан байна.

- 2015 онд үйлдвэрлэлд нийт 624.7 сая төгрөгийн /нөат-гүй/ нүүрс зарцуулсан бөгөөд сар бүрийн эцэст инженерийн тооцсон ТЭЗҮ-ийн мэдээг үндэслэж, үйлдвэрлэсэн дулаанаас хамаарч нүүрсний зарцуулалтын хэмжээг ойролцоолон тооцож, нүүрсийг бөөн дүнгээр зарлагддаг, нүүрсний үлдэгдлийг нүдэн баримжаагаар тоолж, бүртгэж байгаа зэрэг нь зарцуулалтын тооцоо бодитоор гарахгүй байх, тоо мэдээлэл үнэн зөв мэдээлэгдэхгүй байх, үндсэн түүхий эд, материал хяналтгүйгээр зарцуулагдах эрсдлийг дагуулж байна.
- 2015 онд ажилчдад нийт 166 тн нүүрсийг 5.0 сая төгрөгөөр /1 тн 20.0-60.0 мянган төгрөгөөр/, өндөр настнуудад 38.5 тн нүүрсийг 1.0 сая төгрөгөөр /1 тн 20.0-60.0 мянган төгрөгөөр/, гадны иргэдэд 3 тн нүүрсийг 0.2 сая төгрөгөөр /1 тн 60.0-80.0 мянган төгрөгөөр/, аж ахуйн нэгж байгууллагуудад 150,2 тн нүүрсийг 7.9 сая төгрөгөөр /1 тн 32.5-80.0 мянган төгрөгөөр/, нийт 357,7 тн нүүрсний борлуулалт хийсэн нь тодорхой хэмжээнд ажилчид, өндөр настнуудын өвөлжилтийн бэлтгэлийг хангахад дэмжлэг үзүүлж, харилцдаг аж ахуйн нэгж байгууллагуудтайгаа хоорондын тооцоогоор хааж байгаа хэдий ч нүүрсний нөөцийг тогтоосон хэмжээнд байлгаж чаддаггүй, гал алдах магадлал өндөр ажилладаг үйлдвэрийн хувьд үйлдвэрийн эрх ашгийн төлөөх үйл ажиллагаа биш гэж дүгнэж байна.

2015 оны шатахууны худалдан авалт, зарцуулалтыг нарийвчлан авч үзвэл:

- Тус үйлдвэрийн газар нь 2015 онд ганцхан “Жаст ойл” ШТС-тай шууд гэрээ байгуулж 120.4 сая төгрөгийн шатах, тослох материалын худалдан авалт хийсэн байна.
- Материалын зарцуулалтын тайлангаас харахад тайлант онд захирлын автомашинд 8.7 сая төгрөгийн, ерөнхий инженер, ерөнхий нягтлан бодогч нар 4.0 сая төгрөгийн шатахуун, 2016 оны эхний улирлын байдлаар нийт 5.5 сая төгрөгийн шатахуун тус тус зарцуулсан байна. 2012 онд Сэлэнгэ аймгийн Аудитын газраас хийсэн эрсдлийн аудитаар нийт шатахууны 19,8 хувийг буюу 23.5 сая төгрөгийн шатахууныг удирдлагын үйл ажиллагаанд зарцуулсныг үрэлгэн зарцуулалт гэж үзэж цаашид албан ажлын шаардлага, маршрут, ажлын удирдамжийг үндэслэн хэмнэлттэй зарцуулахад анхаарч ажиллах талаар зөвлөмж хүргүүлснийг тодорхой түвшинд хэрэгжүүлэн нийт удирдлагын шатахууны зарцуулалтыг 45,7 хувиар бууруулсан ч зарцуулалтыг

маршрут, шатахууны тооцоо зэрэг нотлох баримтгүйгээр зарлагдаж байна.

Иймээс цаашид удирдлагын шатахууны хэрэглээнд норм норматив тогтоох, маршрут, замын хуудсын дагуу зарцуулах шаардлагатай байна.

3.2 Хөрөнгө нөөцийг хэрэгцээ, шаардлагын хэмжээнд бэлтгэн, ашиглаж байна уу?

Бэлэн мөнгөний хомсдлоос шалтгаалан шаардлагатай нөөцийг бүрдүүлж чадахгүй байна.

Тус үйлдвэрийн газар нь 2015 онд 12.2 сая төгрөгийн үндсэн хөрөнгө, 1,127.7 сая төгрөгийн бараа материал худалдан авч, 1,080.3 сая төгрөгийн бараа материал зарлагдсан байна.

Дулаан үйлдвэрлэлийн горимд сарын 5000-6000 тн нүүрсний нөөцтэй байхаар тогтоосон байдаг боловч алдагдалтай ажиллаж байгаагаас нүүрсний нөөцийг тогтоосон хэмжээнд байлгаж чадахгүй байгаа бөгөөд 2015 оны 10, 12 саруудад нүүрсгүй болж халаалт зогсох хэмжээнд хүрснээр төмөр замын Сүхбаатар өртөөнөөс 2,6 сая төгрөгийн нүүрс, 2016 оны 3 сард “Экопартнерс” ХХК-аас 5,7 сая төгрөгийн нүүрс тус тус худалдан авсан байна.

Бараа материал, сэлбэг хэрэгслийг хэрэгцээ гарсан тухай бүрд нь худалдан авч үйлдвэрлэлд зарцуулж иржээ.

3.3 Хөрөнгийг бүртгэл тооцоонд бүрэн тусгаж, тооллого, тооцоог цаг хугацаанд нь гүйцэтгэж байна уу?

Үйлдвэрийн газрын захирлын 2012 оны 10 сарын 31-ний 72 дугаар тушаалаар “Өмч хамгаалах байнгын зөвлөл”-ийг 5 хүний бүрэлдэхүүнтэйгээр шинэчлэн байгуулсан ч хөрөнгийн орлого, зарлагын хөдлөл, өөрчлөлтөд явцын хяналт хийж дүгнэлт, зөвлөмж өгөөгүй байна.

2012 онд аймгийн Аудитын газраас хийсэн эрсдлийн аудитаар өгөгдсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй, “Өмч хамгаалах байнгын зөвлөл” нь байгууллагын хөрөнгөнд хамаарах үл хөдлөх болон хөдлөх хөрөнгийг эзэмших, ашиглах, үр ашгийг дээшлүүлэхэд зөвлөгөө өгөх, хөрөнгийг шилжүүлэх, худалдах, актлах, данснаас хасах, устгах үндсэн хөрөнгийн талаар дүгнэлт, санал гаргаж холбогдох материалыг хууль тогтоомж, журмын дагуу бүрдүүлэх, эрх бүхий байгууллагаас гарсан шийдвэрийг хэрэгжүүлэх, биелэлтийг тооцож, тайлагнах ажлыг удирдан зохион байгуулах үндсэн үүргээ хэрэгжүүлээгүй байна.

НББ-ийн тухай хуульд заасны дагуу 2015 оны жилийн эцсийн хөрөнгийн тооллогыг ерөнхий инженер Ц.Мөнхдоржоор ахлуулсан комисс байгуулан гүйцэтгэсэн байна. Тооллогын комиссоос ашиглалтын шаардлага хангахгүй болсон дахин ашиглах боломжгүй 11.2 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг актлах шийдвэрийг гаргасан байна.

Аудитын явцад үндсэн хөрөнгийн бүртгэлийг биетээр шалган тулгахад 1998 онд ашиглалтад орсон, 4.9 сая төгрөгийн өртөг бүхий 0.8 сая төгрөгийн

хуримтлагдсан элэгдэлтэй, ашиглалтын хугацаандаа байгаа тракторын граш эвдэрч хэмхэрч, ашиглалтын шаардлага хангахгүй болсон байна.

Мөн бараа материалын дансанд 11 нэр төрлийн 12.4 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг бүртгэсэн байна. Үүнийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт № 13

д/д	Материалын нэр	Тоо ширхэг	Нэгжийн үнэ	Нийт үнэ /мян.төг/
1	Гагнуурын редуктор	1	7800	7,800.0
2	Насос КР-85	1	137.3	137.3
3	Нэмэлт усны насос к-30-45 моторгүй	1	350	350.0
4	Таслагч KEV	5	86	430.0
5	Шүршигч насос /улаан/	1	60	60.0
6	UPS 650VA тог баригч	1	229	229.0
7	Дурантай аппарат	1	198.6	198.6
8	Канон	1	1500	1,500.0
9	Тог баригч	5	160	800.0
10	Ширээ	1	125	125.0
11	Шкаф 2 хаалттай	3	249.9	749.7
Нийт дүн		21		12,379.6

Үндсэн хөрөнгийг бараа материалын дансанд бүртгэснээс хөрөнгийн элэгдэл дутуу байгуулагдан тайлант жилийн зардал дутуу илэрхийлэгдсэн байна.

Дөрөв. Аудитаар илрүүлсэн зөрчил

Хийж гүйцэтгэсэн аудитын дүнд илэрсэн дараах зөрчлүүдэд акт, албан шаардлага бичигдлээ.

Акт

- Байгууллагын ажилчидтай холбоотойгоор 2011 оноос хойш үүссэн, өнөөг хүртэл барагдуулаагүй **11.0** сая төгрөгийн авлагыг барагдуулах төлбөрийн акт;

Албан шаардлага

- Хөрөнгийн ангилал буруу бүртгэсэн 12.4 сая төгрөг;
- Гэрээ зэрэг анхан шатны баримтгүйгээр болон нүүрс олборлох үйл ажиллагаа явуулдаггүй компаниудаас худалдан авсан нүүрс 19.8 сая төгрөг;
- Хөрөнгийн худалдан авалтын гүйцэтгэгчийг хуулийн дагуу сонгон шалгаруулаагүй, үнийн харьцуулалт хэрэглэлгүйгээр шууд худалдан авсан 1,948.2 сая төгрөг зэрэг нийт **1,980.4** сая төгрөгийн зөрчилд албан шаардлага бичигдлээ.

Тав. Дүгнэлт

Аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг гаргаж байна. Үүнд:

1. Аймгийн эрх бүхий албан тушаалтантай гэрээ байгуулж, дүгнүүлээгүй үйлдвэрлэл санхүүгийн төлөвлөгөөг аймгийн ИТХ-аар батлуулж хэрэгжүүлээгүй байна.

2. Үйлдвэрийн газрын үндсэн болон санхүүгийн үйл ажиллагаанд дотоод хяналт хийгдэхгүй, үнэлэлт дүгнэлт өгөгдөхгүй байна.
3. Тус ОНӨААТҮГ-ын УТ-10-УТ-15 хүртэлх шугаманд өртгөтгөл хийгдээгүй нь нүүрс, гэрэл цахилгаан, ус зэрэг үйлдвэрлэлийн гол зардлууд хэтрэх шалтгаан болж байна.
4. Түгээж буй нийт дулааны 60 хувийг айл өрхөд нийлүүлж байгаа ч өртгөөсөө 8,6 дахин бага үнээр борлуулж байгаа нь үйлдвэр алдагдалтай ажиллахад голлон нөлөөлж байна.
5. Үйлдвэрлэл алдагдалтай ажиллаж байгаа өнөөгийн нөхцөлд зайлшгүй хэрэгцээ шаардлага үүсээгүй сонин сэтгүүл захиалга, аялал зугаалгад зориулж тэвчиж болох үр ашиггүй зардал гаргасан байна.
6. Өглөг, авлагыг барагдуулах талаар үр дүнтэй арга хэмжээ авч хэрэгжүүлээгүй нь үйл ажиллагаа явуулах тутам авлага, өглөг нэмэгдэх сөрөг үр дагаварт хүргэж байна.
7. Хөрөнгийн худалдан авалтыг ТБОНӨХБАҮХАТухай хуулийн дагуу сонгон шалгаруулалт зарлаж, үнийн харьцуулалт хийлгүйгээр шууд худалдан авах аргаар гүйцэтгэж байгаа нь зардал нэмэгдэн, алдагдалтай ажиллах нэг нөхцөл болж, ашиг сонирхлын зөрчил үүсэх эрсдлийг дагуулж байна.
8. Удирдлагын шатахууны хэт өндөр зарцуулалтыг тодорхой хэмжээгээр буулгасан ч тогтоосон норм норматив, ажлын удирдамж, маршрутгүйгээр зарцуулах зэргээр бүртгэлээр тавих хяналт сул байна.
9. Үндсэн хөрөнгийг бараа материалын дансанд бүртгэсэн байна.
10. Тус үйлдвэрийн газар нь өөрийн хөрөнгөөр бие даан ажиллах чадваргүй болж, төлбөрийн чадвар алдагдаж, санхүүгийн тогтворгүй байдал үүссэн байна.
11. Шаардлагатай бол дулаан үйлдвэрлэх, түгээх үйл ажиллагааг мэргэжлийн яаманд харьяалуулж, мэргэжлийн удирдлагаар хангуулах, улмаар хуучирсан технологийг шинэчлэх гадаад, дотоодын хөрөнгийн эх үүсвэрийг судалж, хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Зургаа. Аудитын зөвлөмж

Аудитын дүнд үндэслэн дор дурдсан албан тушаалтанд дараах зөвлөмжийг өгч байна.

Аймгийн ИТХ-ын дарга Г.Бямбаа, Засаг дарга Ш.Оргил нарт :

- Сэлэнгэ- Энерго ОНӨААТҮГ-ын захиралтай жил бүр гэрээ байгуулж, дүгнэж байх.
- “Сэлэнгэ Энерго” ОНӨААТҮГ-т зайлшгүй шаардлагатай хөрөнгө оруулалтын ажлуудыг улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар үе шаттайгаар шийдвэрлэх, техник технологийг шинэчлэх арга замыг хайх,
- Шаардлагатай гэж үзвэл тус үйлдвэрийн газрыг холбогдох яаманд харьяалуулж, мэргэжлийн удирдлагаар хангуулах арга хэмжээ авах,
- Орон нутгийн төсөвт төлөх 744.4 сая төгрөгийн өглөгийг тус үйлдвэрийн газрын үйл ажиллагааны үр дүнгээс төлөх боломжгүй байгаад дүгнэлт хийж, данс бүртгэлээс хасах асуудлыг шийдвэрлэх,
- Сэлэнгэ Энерго ОНӨААТҮГ-ын үйл ажиллагаанд тавих дотоод хяналтыг сайжруулж, үйл ажиллагааг дэмжих арга хэмжээ авах,
- Үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөөг жил бүр аймгийн ИТХ-аар баталж,

гүйцэтгэлд нь тогтмол хяналт тавих,

- Төсөвт байгууллагуудаас авах авлагыг барагдуулах арга хэмжээ авах,
- Эрчим хүчний сайдын 2015 оны 09 дүгээр сарын 14-ний өдрийн “Халаалтын улирал эхлэх, дуусах хугацааг тогтоох тухай” 122 дугаар тушаалаар баталсан халаалтын улирлын хугацааг баримталж ажиллах.

Сэлэнгэ энерго ОНӨААТҮГ-ын захирал Э.Эрдэнэбаатарт:

- Орон нутгийн өмчөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авахдаа ТБОНӨХБАҮХА тухай хууль, ЗГ-ын 2013 оны 68 дугаар тогтоолоор баталсан босго үнийн журмыг баримталж ажиллах.
- Байгууллагын “Өмч хамгаалах байнгын зөвлөл”-ийн үйл ажиллагааг эрчимжүүлэн зөвхөн хөрөнгө материалыг данснаас хасах акт тогтоох бус худалдан авалт, ашиглалтад бодитой хяналт тавьж ажиллуулах.
- Алдагдлыг багасгах, ашигтай ажиллах нөхцөл боломжийг судалж, тодорхой үр дүнтэй арга хэмжээ авах.
- Нүүрсний нөөцийг дулаан үйлдвэрлэлийн горимд заасан хэмжээнд байлгах, нүүрсийг үйлдвэрлэгчээс шууд бэлтгэн нийлүүлэх.
- Өөрийн хэрэгцээнд бэлтгэн нийлүүлсэн нүүрсийг гадны компани, иргэдэд борлуулах үйл ажиллагааг зогсоох.

Ерөнхий нягтлан бодогч Д.Ванчигмаад:

- Нягтлан бодох бүртгэлийг НББ-ийн тухай хууль болон НББОУС-д нийцүүлэх.
- Авлага, өглөгийн үлдэгдлийг тайлант хугацаа бүрийн төгсгөлд тооцоо нийлж, баталгаажуулан, санхүүгийн тайланд үнэн зөв тусгаж байх.
- Удирдлагын шатахууны зарцуулалтад тавих хяналтыг сайжруулж, анхан шатны баримт, маршрут, ажлын удирдамжийн дагуу шатахуун зарцуулах, шатахууны хэрэглээний норм тогтоож хэрэгжүүлэх.

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ч.ЭНХТУЯА

АУДИТЫН МЕНЕЖЕР

Б.БАТМӨНХ

ШИНЖЭЭЧ

А.ДАШБАТ